



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/642

Ховд

27 айлын орон сууцны барилгын гаднах дулааны
шугам шинэчлэх ажлыг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Толхын ойл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 27 айлын орон сууцны барилгын гаднах дулааны шугам шинэчлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Н.Цацралцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Р.Янжмаа - Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар - Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Г.Тунгалаг - Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Б.Бямбахүү - Жаргалан багийн Нийгмийн ажилтан

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

Т.Дырдубай - “Толхын ойл” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн
дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа барилга хот байгуулалтын
газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Толхын ойл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН